

ТАНИЛЦУУЛГА

*Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг
дэмжих хөтөлбөрийн талаар*

А.Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын хамтын ажиллагаа

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк /АДБХОБ/-ны гишүүнээр Монгол Улс 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр элссэн байдаг. Үүнээс хойш, "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах хөтөлбөр"-ийн хүрээнд 2020 оны 09 дүгээр сард 100.0 сая ам.долларын санхүүжилттэй төсвийн дэмжлэгийн зээл болон 2021 оны 07 дугаар сард 21.0 сая ам.долларын санхүүжилттэй "КОВИД-19 вакцинжуулалтын арга хэмжээ төсөл"-ийн зээлийн хөрөнгийг тус тус Монгол Улсын Засгийн газарт олгож эдгээр хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

Б. "Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"

"Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд АДБХОБ-ны зүгээс 100.0 сая ам.доллартой тэнцэх зээлийн хөрөнгийг хамтын санхүүжилт¹ хэлбэрээр олгохоор зээлийн хэлэлцээрийг 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хийгээд байна.

БНХАУ-ын баримталж буй "Тэг-КОВИД" бодлогын улмаас тогтоосон хилийн хязгаарлалт болон Оросын Холбооны Улс болон Украин улсуудын хямралт нөхцөл байдлаас шалтгаалан хүнс, эрчим хүчний үнэ огцом нэмэгдэж, нийлүүлэлтийн сүлжээний тасалдлыг бий болгосон. Түүнчлэн инфляцын түвшин өсөж, гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн хямрал улс орнуудын эдийн засагт хүндрэл учруулж байна.

Сүүлийн 40 жилд тохиолдоогүй өндөр инфляцын түвшнийг тогтворжуулахаар улс орнууд Төв банкны бодлогын хүүгээ чангаруулж байгаа ба АНУ-ын Холбооны нөөцийн сан бодлогын хүүг 2022 оны эхний 9 сард 5 удаа эрс нэмэгдүүлсэн нь ам.долларын ханшийг голлох валютуудын эсрэг 15 орчим хувиар өсгөж, хөгжиж буй орнуудад өрийн болон валютын ханшийн дарамтыг нэмэгдүүллээ.

Дэлхийн эдийн засагт үүссэн дээрх сорилтуудын үр дүнд Олон Улсын Валютын сан /ОУВС/-гийн 2022 оны 1 дүгээр сарын "Дэлхийн эдийн засгийн төлөв" тайланд дэлхийн эдийн засаг 2023 онд 3.8 хувиар өсөхөөр төсөөлж байсан бол 3 удаагийн үнэлгээгээр шинэчлэн 2022 оны 10 дугаар сард 2.7 хувь болгон бууруулжээ. Монгол Улсын эдийн засаг 2022 оны эхний хагас жилд 1.9 хувиар өссөн ба хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2.6 хувиар, 2023 онд 5.0 хувиар тус тус өсөх төсөөлөлтэй байна. Инфляцын түвшин 2022 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 14.4 хувьд хүрсэн ба үүний 7.4 хувьд импортын барааны үнийн өсөлт нөлөөлж байгаа юм.

¹ Тус хөтөлбөрийг АХБ-тай хамтран санхүүжүүлэхээр тохиролцсон бөгөөд АХБ-тай зээлийн хэлэлцээрийг 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдөр хийж, зээлийн гэрээнд 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан.

Геополитикийн хурцадмал байдал болон гадаад орчны нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2022 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 1.0 тэрбум ам.доллароор өссөн үзүүлэлттэй байна. Гадаад валютын албан нөөц 2022 оны 8 дугаар сарын байдлаар 2.6 тэрбум ам.долларт хүрснээр оны эхэн үетэй харьцуулахад 1.8 тэрбум ам.доллароор буурчээ.

2022 оны эхний 8 дугаар сард төсвийн тэнцвэржүүлсэн орлого 10.0 их наяд төгрөг, нийт зарлага 10.9 их наяд төгрөгт хүрснээр төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар буурч, 899.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.9 хувьд хүрчээ.

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалсан Монгол Улсын эдийн засагт үүсээд буй инфляц, төлбөрийн тэнцлийн сөрөг нөлөөллийг бууруулахад АДБХОБ-наас олгох "Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр" нь бодлогын дэмжлэг үзүүлэх бөгөөд цаашид тус хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн хөрөнгө нь гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд нэн шаардлагатай байна.

В. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2022 онд 70 хувь, 2023 онд 65 хувь, 2024 оноос эхлэн 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус хуульчлагдсан.

Энэ хүрээнд 2022-2025 оны хооронд эдийн засаг харгалзан 2.8 хувь, 4.5 хувь, 5.1 хувь, 6.1 хувиар өсөж², Монгол Улсын 2022 оны батлагдсан төсөв, 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2022 онд 56.6 хувь, 2023 онд 53.2 хувь, 2024 онд 51.7 хувь болон 2025 онд 47.1 хувьтай тус тус тэнцэхээр тооцоологдсон. Ингэснээр эдгээр онуудад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

"Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээ"-ний хүрээнд авч ашиглах 100.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн эх үүсвэр нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Засгийн газрын нэмэгдүүлэх өрийн дээд хэмжээнд нийцэж байна.

Г. Хөтөлбөрийн шаардлага хангасан байдал

"Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд АДБХОБ болон АХБ-наас 7 шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлага тавьсан. Монгол Улс энэхүү шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаад байгаад бөгөөд доорх хүснэгтээр дэлгэрэнгүйг харууллаа.

² Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг боловсруулахад ашигласан ДНБ-ний өсөлтийн төсөөлөл

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал

№	Шаардлага	Нийцэж буй байдал
1	Гадаад цочролын нөлөөллүүдэд өртсөн байх	КОВИД-19 цар тахлын нөлөөлөл, БНХАУ-ын хилийн хязгаарлалт болон ОХУ-Украины хооронд үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарах хүлээлттэй байгаа бөгөөд шатахуун болон импортын хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан инфляцын дарамт нэмэгдэж, валютын нөөц огцом буураад байна.
2	Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийн зардал	Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад эдийн засгийн хүндрэлийн үед хамгийн их нэрвэгдээд буй нийгмийн эмзэг бүлэгт бодлогын арга хэмжээнүүдийг чиглүүлэх шаардлагатай. Үүнд Хүүхдийн мөнгөн тэтгэмж, цалингийн дэмжлэг олгох, амьжиргааны түвшин доогуур бүсэд цэцэрлэгийн хүрэлцээг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх зэрэг оршино.
3	Макро эдийн засгийн цочролын өмнөх оновчтой менежмент	Монгол Улсын бодит эдийн засгийн өсөлт 2017-2019 онд дунджаар 6.3 хувьтай тэнцэж, Засгийн газрын нийт өрд эзлэх гадаад өрийн хэмжээ 81.4 ³ хувь, төсвийн зарлага ДНБ-ний 30.7 хувьтай тэнцэж байсан. КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс эдгээр үзүүлэлтүүд муудсан бол 2022 оноос эхлэн төсвийн алдагдлыг бууруулах, өрийн бүтцийг сайжруулах зэрэг төсвийн оновчтой менежментийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн.
4	Бүтцийн шинэчлэл хийх	Монгол Улсын Засгийн газар дунд хугацааны бүтцийн шинэчлэлийн хүрээнд 2021 онд "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг батлуулж, эдийн засаг, төсвийн бодлогыг тус баримт бичгийн хүрээнд чиглүүлж байна. Түүнчлэн, санхүүгийн салбарын хувьд системийн ач холбогдол бүхий банкнууд хувьцаа эзэмшигчдийн бүтцийг төрөлжүүлэх, дүрмийн санг нэмэгдүүлэх зорилгоор зах зээлд хувьцаа гаргахаар төлөвлөж байна.
5	Өрийн тогтвортой байдал	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу өнөөгийн үнэ цэнээр Монгол Улсын Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2024 он хүртэл буурч тогтворжих бөгөөд Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг баталснаар өрийн багц дахь зах зээлийн эрсдэл болон хүүгийн зардлыг бууруулах зорилтыг тавьсан.
6	ОУВС-тай хамтран ажиллах	ОУВС-гийн дүрмийн IV зүйлд заасны дагуу ОУВС нь 2021 оны 10 дугаар сарын 01-нээс 05-ны өдрүүдийн хооронд Монгол Улсын Засгийн газартай зөвлөлдөх уулзалтыг хийсэн. Үүний үр дүнд 2021 оны 11 дүгээр сарын 19-нд ОУВС-гийн ажилтнуудын ажлын тайланг Гүйцэтгэх зөвлөлд хэлэлцүүлсэн. IV-р зүйлийн

³ Азийн дэд бүтцийн банк, Азийн хөгжлийн банкны тооцоолол

		ээлжит ажлын хэсгийн томилолтоос гадна хяналтын ажлын хэсгийг 2022 оны 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 03-ны өдрийн хооронд ОУВС, Засгийн газартай хамтран байгуулан ажилласан.
7	Хяналт шинжилгээ, үнэлгээ	Засгийн газар Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг ил тод мэдээлэх хяналт шинжилгээ, үнэлгээний механизмыг бий болгохоор болсон. Үүнд, улирлын тайлангуудыг бэлтгэж, эдгээр тайлан, дүн шинжилгээнд ажлын хэсэг хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэнэ.

* Эх сурвалж. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Азийн хөгжлийн банк

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь АДБХОБ-наас 100.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөж байна. Энэхүү зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 7 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 3 жил байх ба хүүгийн түвшний хувьд хөвөгч суурь хүү болох Баталгаат овернайт санхүүжилтийн хүү⁴ дээр 0.81 хувийн нэмэгдэлтэй байна.

Тус хөтөлбөрийн үндсэн зорилго нь нийгэм, эдийн засагт учраад буй сөрөг шокийн үед нийт хүн ам, тэр дундаа эмзэг, ядуу иргэдийн өртөмтгий байдлыг бууруулахад чиглэсэн бөгөөд хөтөлбөрийн хамрах хүрээ, загвар болон хяналтын механизмын хүрээнд АХБ болон АДБХОБ-тай тохирсон тоон шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг улирал бүр тайлагнах юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

⁴ Secured overnight financing rate (SOFR)